



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 0/1934

Улаанбаатар хот

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/821 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 41,238,150.0 /дөчин нэгэн сая хоёр зуун гучин найман мянга нэг зуун тавин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга Д.Төмөрбаатарт тус тус даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050000933

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 07 дугаар сарын 06 -ний өдрийн
01934 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

/төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	Хьюндай грейс 43-59 УНН	10,000,000.0	10,000,000.0	0.0
2		Хьюндай аксент 68-25 УБС	20,573,850.0	20,573,850.0	0.0
3		Форд мондео 28-52 УНР	10,664,300.0	10,664,300.0	0.0
Дүн			41,238,150.0	41,238,150.0	0.0